



“УЛААНБААТАР ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 25 53, Факс: (976 11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024-06-04 № 01/1074

танай _____-ны № _____-т


Тендер түдгэлзүүлэх тухай

Танай компаниас зарласан “Харуул хамгаалалтын үйлчилгээ” УБЦТС/20240103074 дугаартай тендерийн баримт бичигт “Өлзий хишиг гранд” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерт холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер шалгаруулалтын баримт бичгийг авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбогдох тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг, бусад баримт материалыг нотлох баримтын шаардлага хангуулан албан бичгээр болон цахим шуудангаар (davaajargal@afccp.gov.mn) 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0002352